

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь төрийн аудитын байгууллагын цахим мэдээллийн нэгдсэн системийн хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Хөндлөнгийн мэдээллийн санг төрийн аудитын байгууллага хуульд заасан аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхэд ашиглана.
- 1.3. Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “энэ хуулийн 13.2-т заасан системийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас аудитад шаардлагатай мэдээллийг гаргуулах” гэсний дагуу төрийн захиргааны төв байгууллага (яам), түүний харьяа захиргааны байгууллага (агентлаг)-ын, Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.11-д “Төрийн аудитын байгууллага хуульд заасан аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан” гэсний дагуу банкны мэдэлд цахим хэлбэрээр оршин байгаа мэдээллийг авч, энэ журмын 1.1-д тусгасан гаднын мэдээллийн санг бүрдүүлэхэд энэ журмыг баримтална.
- 1.4. Энэ гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.4.1. “ХУР” гэж төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах зохицуулалт бүхий “Үндэсний Дата Төв” УТҮГ-т байрших мэдээлэл солилцооны системийг хэлнэ.
 - 1.4.2. “Төрийн мэдээллийн сан бүрдүүлэгч” гэж төрийн бүртгэл, мэдээлэл хөтөлдөг “ХУР” системээр дамжуулан мэдээллээ түгээж буй захиргааны байгууллагыг хэлнэ.
 - 1.4.3. “Веб сервис” гэж кибер орчинд мэдээлэл солилцох үйлчилгээг хэлнэ.

Хоёр. Хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх

- 2.1. Төрийн аудитын байгууллагын хөндлөнгийн мэдээлэл нь дараах төрөлтэй байна. Үүнд:
 - 2.1.1. Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа захиргааны байгууллагаас цуглуулах мэдээлэл;
 - 2.1.2. Банкнаас цуглуулах мэдээлэл;
 - 2.1.3. Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчаас цуглуулах мэдээлэл;
 - 2.1.4. Бусад мэдээлэл.
- 2.2. Энэ журмын 2.1-д заасан мэдээллийг Төрийн аудитын тухай хуулийн 15.1.5, Банкны тухай хуулийн 7.2.11-д заасны дагуу тус тус бүрдүүлнэ.
- 2.3. ҮАГ-ын мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь веб сервисээр дамжуулан гаднын мэдээллийг цуглуулна.
- 2.4. Энэ журмын 2.1.1, 2.1.2-д заасан мэдээллийг авахдаа Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа захиргааны байгууллага, банкны байгууллагатай “мэдээлэл авах гэрээ” байгуулан, веб сервисээр дамжуулан авна. Мэдээлэл авах гэрээнд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 2.4.1. Мэдээллийн нэр, сервисийн нэр;
 - 2.4.2. Сервисийн дэлгэрэнгүй тайлбар;
 - 2.4.3. “Оролт”, “Гаралт”-ын утгууд;

- 2.4.4. Зориулалт;
 - 2.4.5. Талуудын эрх, үүрэг;
 - 2.4.6. Бусад шаардлагатай мэдээлэл;
 - 2.4.7. Гэрээний сервисийн баримт бичиг. Мэдээлэл авах байгууллагын мэдээллийн технологийн ажилтанд гадаад хэрэглэгчийн нэр, нууц үг олгох бол сервисийн баримт бичигт тусгана.
- 2.5. Энэ журмын 2.4.1-ээс 2.4.6-д тусгасан зүйл нь өөрчлөгдөх тохиолдолд 2.4-д тусгасан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлнэ.
- 2.6. Энэ журмын 2.1.3, 2.1.4-т тусгасан мэдээллийг Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн аудиттай холбоотой болон холбоогүй боловч бусад аудитад ашиглагдаж болох мэдээллийг холбогдох хөндлөнгийн мэдээллийн системд бүртгэнэ.
- 2.7. Энэ журмын 2.4-д заасан гэрээ байгуулан веб сервисээр авсан мэдээлэл болон аудитын явцад олж илрүүлсэн энэ журмын 2.1.3-д заасан мэдээллийн бүртгэлийг хөтлөхдөө дараах үзүүлэлтээр бүртгэнэ. Үүнд:
- 2.7.1. Мэдээлэл илгээгчийн нэр;
 - 2.7.2. Мэдээллийн төрөл;
 - 2.7.3. Мэдээлэл ирүүлсэн хэлбэр;
 - 2.7.4. Мэдээллийн тоо хэмжээ;
 - 2.7.5. Мэдээллийг хүлээн авсан огноо.
- 2.8. Хөндлөнгийн мэдээллийг цуглуулах арга зам, хөтлөх хэлбэр, хугацаа нь мэдээллийн төрлөөс шалтгаалан харилцан адилгүй байж болно.
- 2.9. Хөндлөнгийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахад үүлэн тооцоолуур ашиглах тохиолдолд дэд бүтэц нь Үндэсний дата төвд байршина.

Гурав. Мэдээллийн төрөл, мэдээллийг ашиглах

- 3.1. Энэ журмын 2.1.1-д тусгасан байгууллагын мэдэлд буй дараах мэдээллийн төрөл байна.
- 3.1.1. Сангийн яам:
 - 3.1.1.1. Төрийн сангийн дансны бүртгэл, дансны хуулганы мэдээлэл;
 - 3.1.1.2. Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн мэдээлэл;
 - 3.1.1.3. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн мэдээлэл;
 - 3.1.1.4. Бусад мэдээлэл.
 - 3.1.2. Татварын ерөнхий газар:
 - 3.1.2.1. Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл;
 - 3.1.2.2. Татвар ногдуулалт, төлөлтийн бүртгэлийн мэдээлэл;
 - 3.1.2.3. Татварын өрийн мэдээлэл;
 - 3.1.2.4. И-баримтын мэдээлэл;
 - 3.1.2.5. Бусад мэдээлэл.
 - 3.1.3. Гаалийн ерөнхий газар:
 - 3.1.3.1. Гаалийн албан татвар, төлбөр, хураамжийн мэдээлэл;
 - 3.1.3.2. Бусад мэдээлэл.
 - 3.1.4. Монгол банк:
 - 3.1.4.1. Төрийн болон орон нутгийн оролцоотой этгээдийн арилжааны банканд байршиж буй дансны бүртгэл, дансны гүйлгээний мэдээлэл.
 - 3.1.5. Улсын бүртгэлийн ерөнхий газар:

- 3.1.5.1. “ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем.
 - 3.1.6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар:
 - 3.1.6.1. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой этгээдийн бүртгэлийн мэдээлэл.
 - 3.1.7. Төрийн худалдан авах ажиллагааны газар:
 - 3.1.7.1. Тендер шалгаруулалтын цахим системийн мэдээлэл.
 - 3.1.8. Төрийн албаны зөвлөл:
 - 3.1.8.1. Төрийн албан хаагчдын мэдээлэл.
 - 3.1.9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам:
 - 3.1.9.1. Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын нэгдсэн системийн мэдээлэл.
 - 3.1.9.2. Эрүүл мэндийн даатгалын сан, эрүүл мэндийн болон даатгалын нэгдсэн системийн мэдээлэл.
 - 3.1.9.3. Халамж, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээлэл.
 - 3.1.10. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар:
 - 3.1.10.1. И-Монголия портал сайтын мэдээлэл.
 - 3.1.11. Бусад байгууллагын холбогдох мэдээлэл.
- 3.2. Мэдээллийн сан дахь өгөгдөл, мэдээллийг аудит хийх чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийн хэрэгцээ шаардлагын дагуу боловсруулах, үйл ажиллагаандаа ашиглах чиглэлийг Үндэсний аудитын газрын аудитын ерөнхий бодлого, чиглэлийг тодорхойлж, аудитыг нэгдсэн хяналт, удирдлагаар хангах, үр дүнг нэгтгэн тайлагнах асуудал хариуцсан нэгж (Аудитын нэгдүгээр газар) тодорхойлж, ҮАГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, аймаг нийслэл дэх төрийн аудитын газар аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ашиглана.

Дөрөв. Мэдээлэл авах, веб сервист холбогдох, хадгалах

- 4.1. Төрийн аудитын байгууллага Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа захиргааны байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцоход хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл солилцох веб сервисээр дамжуулан авна.
- 4.2. Веб сервисээс бусад хэлбэрээр авсан мэдээллийг хөндлөнгийн мэдээллийн санд, мэдээлэл ирүүлэгчийн нэрээр бүртгэнэ.
- 4.3. Төрийн аудитын байгууллага энэ журмын 2.1.1-д тусгасан мэдээллийг цуглуулахдаа Үндэсний дата төвтэй хамтран ажиллаж, мэдээлэл цуглуулахад шаардлагатай стандарт, хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллана.
- 4.4. Хөндлөнгийн мэдээллийн сангийн мэдээллийг хадгалж, хамгаалахдаа “Аудитад цахим системийг ашиглах журам”-ын 6 дугаар бүлэг “Мэдээллийн санг хадгалах, дамжуулах”-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тав. Хориглох зүйл

- 5.1. Мэдээлэл авах веб сервист холбогдох програм хангамжийн хөгжүүлэлтийг гадаад улсын иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 5.2. Мэдээллийг хувийн эзэмшлийн сервер, компьютер, тоног төхөөрөмж, хяналтаас гадуур бусад орчинд боловсруулахыг хориглоно.

5.3. Төрийн аудитын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор цуглуулсан энэ журамд заасан мэдээллийг аудитын бус зориулалтаар ашиглах, хуулбарлах, бусдад дамжуулах, задруулахыг хориглоно.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----o0o-----